

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/17/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТ

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
<b>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....</b>	<b>5</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
<b>3. Аудитын тайлан.....</b>	<b>13</b>
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
<b>4. Аудитын илрүүлэлт .....</b>	<b>18</b>
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Албан шаардлага.....	19
4.3 Зөвлөмж .....	19
<b>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....</b>	<b>21</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШША	Шүүхийн шинжилгээний алба
ШШҮХ	Шүүхийн Шинжилгээний Үндэсний хүрээлэн
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, Илгээл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/59  
танай \_\_\_\_\_-ныг № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН ШҮҮХИЙН  
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ  
ДАРГА Ө.СЭР-ОД ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,198,244.42</b>	<b>10,282,305.57</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,928,469.57</b>	<b>688,469.57</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,928,469.57	688,469.57
3121	Төгрөг	1,928,469.57	688,469.57
31211	Төрийн сангийн харилцах	1,928,469.57	688,469.57
33	АВЛАГА	18,874.85	51,206.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	18,874.85	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>-</b>	<b>51,206.00</b>
<b>3351</b>	<b>Байгууллагаас авах авлага</b>	<b>-</b>	<b>51,206.00</b>
35	БАРАА МАТЕРИАЛ	6,250,900.00	9,542,630.00
351	Түүхий эд материал	412,500.00	811,200.00
35130	Эм боох материал	412,500.00	811,200.00
354	Хангамжийн материал	5,838,400.00	8,731,430.00
35420	Аж ахуйн материал	3,524,240.00	5,475,840.00
35440	Түлш, шатах тослох материал	2,314,160.00	3,255,590.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>65,956,321.28</b>	<b>71,202,246.74</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>65,956,321.28</b>	<b>71,202,246.74</b>
392	Биет хөрөнгө	56,356,321.28	61,602,246.74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,940,572.50	70,940,572.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,874,414.32)	(39,113,871.60)
<b>39205</b>	<b>Машин тоног төхөөрөмж (компьютер)</b>	<b>54,146,005.64</b>	<b>67,476,187.64</b>
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,756,225.20)	(45,090,239.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,379,305.84	14,699,105.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,478,923.18)	(7,309,508.48)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>9,600,000.00</b>	<b>9,600,000.00</b>
<b>39303</b>	<b>Бусад биет бус хөрөнгө</b>	<b>9,600,000.00</b>	<b>9,600,000.00</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>74,154,565.70</b>	<b>81,484,552.31</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>74,154,565.70</b>	<b>81,484,552.31</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	74,154,565.70	81,484,552.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	33,056,986.97	33,056,986.97
51101	Өмч: - төрийн	33,056,986.97	33,056,986.97
512	Хуримтлагдсан үр дүн	41,097,578.73	48,427,565.34
51210	Өмнөх үеийн үр дүн	41,097,578.73	41,097,578.73
<b>51220</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>-</b>	<b>7,329,986.61</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>74,154,565.70</b>	<b>81,484,552.31</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	296,772,161.36	275,431,882.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,134,761.36	22,729,182.00
120	Нийтлэг татварын бус орлого	46,134,761.36	22,729,182.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,584,370.79	22,729,182.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,797,300.00	4,990,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,787,070.79	11,649,982.00
120009	Бусад орлого	1,550,390.57	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,637,400.00	252,702,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	250,637,400.00	249,816,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,637,400.00	249,816,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,886,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	-	2,886,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	270,514,898.85	268,101,895.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	270,514,898.85	268,101,895.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	268,452,219.31	265,215,552.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,421,599.97	204,025,319.40
210101	Үндсэн цалин	121,034,004.32	177,236,863.40
210102	Нэмэгдэл	67,887,465.65	23,606,896.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,500,130.00	3,181,560.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,022,043.60	4,532,422.66
210201	Тэтгэврийн даатгал	167,674.00	346,979.39
210202	Тэтгэмжийн даатгал	125,100.00	40,151.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,900.00	32,121.20
210204	Ажилгүйдлийн даатгал	125,100.00	8,030.30
210205	Эрүүл мэндийн даатгал	4,579,269.60	4,105,140.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,138,254.00	12,415,823.00
210301	Гэрэл, цахилгаан	1,652,000.00	1,962,259.00
210302	Түлш, халаалт	7,641,040.00	7,641,040.00
210303	Цэвэр, бохир ус	2,645,214.00	2,812,524.00
210304	Байрны түрээс	200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	14,538,390.00	19,091,919.00
210401	Бичиг хэрэг	1,447,900.00	2,136,100.00
210402	Тээвэр, шатахуун	10,814,740.00	11,941,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,387,900.00	1,399,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	293,200.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	594,650.00	3,374,839.00
2105	Нормативт зардал	6,702,730.00	5,737,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,361,730.00	5,737,000.00
210502	Хоол, хүнс	2,341,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,046,900.00	1,270,978.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	707,300.00	595,000.00
210604	Урсгал засвар	1,139,600.00	675,978.00
2107	Томилолт, зочны зардал	5,956,600.00	4,500,000.00
210702	Дотоод албан томилолт	5,956,600.00	4,500,000.00

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,215,510.00	2,238,034.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	703,680.00	1,688,070.00
210803	Даатгалын үйлчилгээ	199,500.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,830.00	199,964.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,500.00	50,000.00
210807	Газрын төлбөр	85,000.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,410,191.74	11,404,056.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,410,191.74	11,404,056.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,062,679.54	2,886,342.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,610,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,610,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,062,679.54	1,276,342.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,062,679.54	1,276,342.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	26,257,262.51	7,329,986.61
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	26,257,262.51	7,329,986.61

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	261,985,090.57	257,692,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,347,690.57	4,990,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,347,690.57	4,990,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,797,300.00	4,990,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,797,300.00	4,990,000.00
120009	Бусад орлого	1,550,390.57	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,637,400.00	252,702,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	250,637,400.00	249,816,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,637,400.00	249,816,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,886,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,886,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	260,434,700.90	258,932,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	260,434,700.90	258,932,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,372,021.36	256,046,357.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,149,000.90	204,025,319.40
210101	Үндсэн цалин	137,136,647.90	177,236,863.40
210102	Нэмэгдэл	56,816,954.00	23,606,896.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,195,399.00	3,181,560.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,813,086.46	4,513,547.81
210201	Тэтгэврийн даатгал	524,674.00	346,979.39
210202	Тэтгэмжийн даатгал	125,100.00	40,151.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,900.00	32,121.20
210204	Ажилгүйдлийн даатгал	125,100.00	8,030.30
210205	Эрүүл мэндийн даатгал	5,013,312.46	4,086,265.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,138,254.00	12,467,029.00
210301	Гэрэл, цахилгаан	1,652,000.00	1,962,259.00
210302	Түлш, халаалт	7,641,040.00	7,473,300.00
210303	Цэвэр, бохир ус	2,645,214.00	3,031,470.00
210304	Байрны түрээс	200,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	16,968,620.00	20,925,439.00
210401	Бичиг хэрэг	1,447,900.00	2,188,200.00
210402	Тээвэр, шатахуун	13,128,900.00	12,998,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,387,900.00	1,399,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	293,200.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	710,720.00	4,099,829.00
2105	Нормативт зардал	6,717,080.00	5,400,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,376,080.00	5,400,000.00
210502	Хоол, хүнс	2,341,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,422,150.00	1,425,978.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	742,450.00	750,000.00
210604	Урсгал засвар	1,479,700.00	675,978.00
2107	Томилолт, зочны зардал	5,956,600.00	4,500,000.00
210702	Дотоод албан томилолт	5,956,600.00	4,500,000.00

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,207,230.00	2,789,044.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	695,400.00	2,239,080.00
210803	Даатгалын үйлчилгээ	199,500.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,830.00	199,964.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	46,500.00	50,000.00
210807	Газрын төлбөр	85,000.00	100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,062,679.54	2,886,342.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,610,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,610,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,062,679.54	1,276,342.79
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,062,679.54	1,276,342.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,550,389.67	(1,240,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,550,389.67	(1,240,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	378,079.00	1,928,469.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,928,468.67	688,469.57

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	33,056,986.97	00.00	14,840,315.32	47,897,302.29
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	33,056,986.97	00.00	14,840,315.32	47,897,302.29
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	26,257,262.51	26,257,262.51
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	33,056,986.97	00.00	41,097,578.73	74,154,565.70
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	33,056,986.97	00.00	41,097,578.73	74,154,565.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	33,056,986.97	00.00	41,097,578.73	74,154,565.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,329,986.61	7,329,986.61
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	33,056,986.97	00.00	48,427,565.34	81,484,552.31

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,316,700.00	253,530,379.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	255,316,700.00	253,530,379.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	255,316,700.00	253,530,379.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,205,900.00	204,025,319.40
210101	Үндсэн цалин	114,004,100.00	177,236,863.40
210102	Нэмэгдэл	72,121,800.00	23,606,896.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,080,000.00	3,181,560.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,564,300.00	4,513,547.81
210201	Тэтгэврийн даатгал	-	346,979.39
210202	Тэтгэмжийн даатгал	-	40,151.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	32,121.20
210204	Ажилгүйдлийн даатгал	-	8,030.30
210205	Эрүүл мэндийн даатгал	4,564,300.00	4,086,265.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,953,300.00	12,467,029.00
210301	Гэрэл, цахилгаан	2,180,000.00	1,962,259.00
210302	Түлш, халаалт	7,473,300.00	7,473,300.00
210303	Цэвэр, бохир ус	3,300,000.00	3,031,470.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,793,200.00	20,725,439.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,988,200.00
210402	Тээвэр, шатахуун	13,000,000.00	12,998,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000.00	1,399,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	293,200.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,100,000.00	4,099,829.00
2105	Нормативт зардал	5,000,000.00	5,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	750,000.00	750,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,500,000.00	4,500,000.00
210702	Дотоод албан томилолт	4,500,000.00	4,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,550,000.00	1,549,044.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,000,000.00	999,080.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	199,964.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	50,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	254,316,700.00	254,020,379.21
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	249,816,700.00	249,030,379.21
131001	Улсын төсвөөс санхүүжих	249,816,700.00	249,030,379.21
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,500,000.00	4,990,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	4,990,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,928,469.57
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	688,469.57

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	2,885,978.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	2,885,978.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,975,978.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	200,000.00
210401	Бичиг хэрэг	-	200,000.00
2105	Нормативт зардал	-	400,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	400,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	675,978.00
210604	Урсгал засвар	-	675,978.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	-	700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил	-	700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	910,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	910,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	910,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	2,886,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,886,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны ху	-	2,886,000.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь гэмт хэргийн газрын үзлэгт оролцож ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлж, хэрэг бүртгэгч /хэрэг бүртгэх/, мөрдөн байцаах, прокурор, шүүхийн байгууллагын тогтоол шийдвэрээр криминалистик, шүүх эмнэлэг, нягтлан бодох бүртгэлийн шинжилгээ хийж магадлагаа, дүгнэлт гаргах, мэдээллийн сан бүрдүүлж ажиллах үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа байгууллага юм.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шинжилгээг тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд тал бүрээс нь бүрэн, бодитой хийх
- Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуултын дагуу шинжилгээ хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах
- Хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийг хүндэтгэн хүнлэг харьцах;
- Тусгай мэдлэг бүхий мөрдөгчтэй хамтран ажиллах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг шинээр боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/17 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байна. Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь дотоод хяналттай

холбоотой журам боловсруулж батлаагүй байна. Албаны даргын тушаалаар 2021 оны дотоод хяналт шалгалт ажлын төлөвлөгөө хуваарийг баталсан.

Шүүхийн шинжилгээний албаны Дотоод хяналтын хороо нь 2021 оны жилийн ажлын төлөвлөгөөнд сахилга хариуцлага, санхүүгийн үйл ажиллагааны талаар 14 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос 1,5 хувиар буюу 4,451.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,338.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,5 хувиар буюу 4.13165 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,098.6 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 320.1 мянган төгрөгөөр буурсан байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний алба 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

**Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:**

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 249,816.7 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Үндсэн үйл ажиллагааны орлого 4,500.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 4,990.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 110,9 хувийн биелэлттэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд төлөвлөгөөнөөс давсан орлого 2,886.0 мянган төгрөгийг буцаан олгосон байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 257,692.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд Буянт мянгад ХХК 5,000.0 мянган төгрөг, Нуган ХХК 5,160.0 мянган төгрөг, Саммит ком ХХК 3,170.2 мянган төгрөг, Анун ХХК 3,319.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандивласныг бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансанд ОБГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,089.2 мянган төгрөгийн амны хаалт, комбинезоныг бараа материалыг орлогоор бүртгэсэн байна. Нийт 6,250.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч, 26,463.6 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна

**Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар цэвэр бохир усны авлага 51.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 сарын 31-ний байдлаар ахмадын сангийн дансанд 688.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлага данс 51.2 мянган төгрөг, бараа материал 9,542.6 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 71,202.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,928.47	688.47	1,240.00
Авлага	18.87	51.21	(32.33)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	6,250.90	9,542.63	(3,291.73)
Үндсэн хөрөнгө	65,956.32	71,202.25	(5,245.93)
Нийт хөрөнгө	74,154.57	81,484.55	(7,329.99)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	74,154.57	81,484.55	(7,329.99)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	74,154.57	81,484.55	(7,329.99)

Авлагын дансны үлдэгдэл нь Төв Чандмань ДЭХГ-т илүү шилжүүлсэн 51.2 мянган төгрөг байна. Бараа материалын дансны үлдэгдэл 9,542.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 3,291.7 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 1,951.6 мянган төгрөгөөр, түлш шатах тослох материалын үлдэгдэл 941.4 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын үлдэгдэл өсөхөд шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 71,202.3 мянган төгрөг болж 5,245.9 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар 16,649.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө өгсөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 74,154.6 мянган төгрөг болж 7,329.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 317,895.6 мянган төгрөгөөр төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 63,578.9 мянган төгрөгөөр бууруулан 254,316.7 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн зардал, нормативд зардал хасагдсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 249,030.4 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 4,990.0 мянган төгрөгийн орлого орж үндсэн үйл ажиллагаанд 251,430.4 мянган төгрөг, тэтгэмж урамшуулалд 1,610.0 мянган төгрөг зарцуулж, 1,276.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ШШҮХ-ээс орлогын төлөвлөгөөг биелүүлсний урамшуулал болгож 2,886.0 мянган төгрөгийн санхүүжилт авч ковид-19-тэй холбоотой бээлий, өмсгөл авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд онцлох асуудал байхгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Авлагын журналд ажиллагсадаас авах авлагын эхний үлдэгдэл, цалингийн урьдчилгаа дансны эхний болон эцсийн үлдэгдэл 1,580.2 мянган төгрөгийг хасах дүнтэй тайлагнасан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан төлөвтэй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж, бараа материалыг зөв ангилан бүртгэж тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 сарын 10-ны өдрийн №1/784 тоот албан бичгээр ирүүлж зөрчлийг таслан зогсоосон байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний албаны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,283.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,806.87 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,476.2 мянган төгрөгийн албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд зөвлөмж өгөв.

##### 4.1 Залруулсан алдаа

4.1.1 Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 1,137.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн

4.1.2 Авлагын журналд ажиллагсдаас авах авлагын эхний үлдэгдэл, цалингийн урьдчилгаа дансны эхний болон эцсийн үлдэгдэл 1,580.2 мянган төгрөгийг хасах дүнтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх." гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн

4.1.3 Ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн онцгой комиссоос олгосон 1,089.2 мянган төгрөгийн амны хаалт, комбинзоныг бараа материалын дансанд орлогод авч тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг

бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8-р заалтыг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх.” гэсэн заалтыг үндэслэж залруулга хийсэн

## 4.2 Албан шаардлага

4.2.1 Харилцагч байгууллагатай хийсэн 3,476.2 мянган төгрөгийн худалдан авалтыг Татварын цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “Аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

## 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Шилэн данстай холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг хангаж ажиллах, байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Шүүхийн шинжилгээний алба	5	7,283.0	3	3,806.8			1	3,476.2	1	